



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.07.04 № 287

танай _____-ны № _____-т

ТУХАЙН ШАТНЫ
СОНГУУЛИЙН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох "Дархан-Уул аймгийн Ардчилсан нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох "Дархан-Уул аймгийн Ардчилсан нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

009070381

холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

“Дархан-Уул аймгийн Ардчилсан нам”-ын орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Дархан-Уул аймгийн Ардчилсан нам”-ын мөрийн хөтөлбөр (.....хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: “Дархан-Уул аймгийн Ардчилсан нам”-д

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.МӨНХБАЯР



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН
АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Дархан-Уул аймгийн Ардчилсан намын гишүүд, дэмжигчид бид өнгөрсөн он жилүүдэд Дархан хот болон Шарын гол, Хонгор, Орхон сумдын хөгжлийн үйл явцыг ул суурьтай судлан, нэгтгэн дүгнэсний үндсэн дээр Дархан-Уул аймгийн нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх төлөвлөгөө бүхий мөрийн хөтөлбөрөө Дарханчууд Та бүхэндээ өргөн дэвшүүлж байна.

● Дархан-Уул аймгийн Ардчилсан нам 2024 оны аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд Дарханы хөгжлийн шинэ үеийг эхлүүлэх мэдлэг чадвартай, туршлагатай, мэргэшсэн, салбар салбартаа манлайлагч залуусаар багаа бүрдүүлэн оролцож байна.

Дархан-Уул аймгийн Ардчилсан нам Мөрийн хөтөлбөрөө хот судлал, төлөвлөлт, төрийн алба, боловсрол, эрүүл мэндийн, эрчим хүч, спорт, хууль эрх зүйн салбарт ажиллаж туршлага хуримтлуулсан ахмад, дунд, залуу үеийн төлөөлөл болсон эрдэмтэн, судлаачидтай хамтран Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн, алс хэтийн чиг хандлагад үндэслэн боловсруулсан болно.

Дархан-Уул аймгийн Ардчилсан намын 2024 оны аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулийн Мөрийн хөтөлбөрийн гол үзэл баримтлал нь Дархан-Уул аймгаа Монгол Улсын Төвийн бүсийн аж үйлдвэр, тээвэр ложистик, худалдаа, үйлчилгээний зангилаа төв болгон хөгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлж, Дарханчууд Дархандаа нүүр бардам, бахархал дүүрэн сурч боловсорч, амар тайван ажиллаж амьдрах нийгэм, эдийн засгийн эрх чөлөөтэй суурь нөхцлийг бий болгоход чиглэж байгаа билээ.

Дархан-Уул аймгийг хотын статустай болгон хөгжүүлэхтэй уялдуулан орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоог бий болгох, жил тутам өсөн нэмэгдэж буй эрчим хүчний эрэлт, хэрэгцээг хангах бүтээн байгуулалтыг эхлүүлэх, иргэдийнхээ хөгжих боломжийг хангасан хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй эрүүл чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй хот болох, ур чадвартай, авъяаслаг залуус шинээр ирж суурьших нөхцлийг бий болгосон далайцтай бодлого, стратегийг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө.

Дархан-Уул аймгийн Ардчилсан нам энэхүү Мөрийн хөтөлбөрийг Дарханчуудынхаа дэмжлэгтэйгээр хэрэгжүүлснээр тулгамдсан асуудал болоод байгаа иргэдийн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, амьдралын чанарыг өөд нь татах шийдэмгий алхам болно гэдэг бид ҮРЭН итгэлтэй байна.

Дарханы маань ирээдүйн хөгжил дэвшилд хотын, орон нутгийн удирдлагын шинэлэг, алсын хараатай сэтгэлгээ, оновчтой гарц, шийдэл ус агаар мэт дутагдаж байгаа энэ цаг үед Дарханчуудын маань сонголт мэргэн байж, аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгох сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшигчдийг дэмжиж саналаа өгнө гэдэгт эргэлзэхгүй байна.

“ДАРХАН - 10/30”

Дарханы Хүүхдүүд

1. Дархан-Уул аймгийн хэмжээнд цэцэрлэг, сургуулийн нэг ангийн хүүхдийн тоог 30-аас хэтрүүлэхгүй, сургалтын шинэ стандарт хэрэгжүүлнэ.
2. СӨБ, ЕБС-ийн Хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаа буюу дугуйлангийн тоог нэмэгдүүлэхийг дэмжинэ.
3. Дархан хотод сургуулийн автобус ажиллуулж, хүүхдүүд сургуульдаа аюулгүй ирж, буцах нөхцөл бүрдүүлнэ.
4. Дугуйн болон явган алхалтын замын сүлжээг нэмэгдүүлж сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхэд аюулгүй, чөлөөтэй зорчих боломжийг бүрдүүлэх зорилгоор "Эрдмийн зам" төслийг хэрэгжүүлэн, хүүхдэд тохиолдох аливаа эрсдлийг арилгана.
5. Хүүхэд чөлөөт цагаараа эрүүл мэнд, бие бялдрын зөв дадал эзэмших орчин, нөхцлийг орон сууцны гадна талбай, сургуулийн орчинд бүрдүүлнэ.
6. Өсвөр насны хүүхдүүдийн дунд болон сургуулийн орчин дахь гадуурхалтыг онцгойлон анхаарч, эцэг эхчүүд, хүүхдүүд, багш, хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллагын уялдаа холбоог сайжруулан, энэ чиглэлээ сэтгэл зүй, харилцааны чиглэлийн мэргэжилтнийг дэмжих, бэлтгэх чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлнэ.
7. Эмзэг бүлгийн, эцэг эх нь асран хамгаалах боломжгүй хүүхдүүдийг сургууль дээр нь хамгаалах чиглэлд бодиттой ахиц гарган.
8. Сурагчид сургуулийн орчин, анги танхимаа бүрэн дүүрэн ашиглаж давтлага, бэлтгэх сургуулилт хийх, хамтран хөгжих, амьд харилцаа үүсгэх боломжоор хангана.
9. Шинэ, хуучин Дарханы сургуулийн орчны ялгааг арилгана.
10. Хүүхэд залуучуудын сурч боловсрох орчинг бүрдүүлж төрөл бүрийн секц, дугуйлангийн үйл ажиллагааг дэмжиж, нэмэгдүүлэн хүүхэд бүрийг хөнгөлөлттэй хамруулах үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.
11. Цахим e-sport-ийг хүүхэд залуучууд зөв зохистой хэрэглэх талаар сургалт сурталчилгаа явуулж цахим ертөнцөд сурч боловсрох тал дээр идэвхийлэн анхаарч бодлогоор дэмжинэ.
12. Сурагчдыг сэтгэцэд нөлөөлөх хорт бодисын нөлөөлөлд автах хууль бус үзэгдэлтэй эрс хатуу тэмцэнэ.
13. Аймгийн боловсролын асуудал хариуцсан байгууллагын дэргэд зөвлөгөө, сургалт, мэдээлэл өгөх төвийг байгуулан ажиллуулж Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөд мэргэжлийн чиг баримжаа олгох, ирээдүйгээ зөв тодорхойлох, гадаадын их дээд сургуульд элсэн суралцахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.

- 26. Усалгаатай тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн ус, эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй техник, технологийн хангамжийг сайжруулж, нэгж талбайгаас авах ургацыг дээшлүүлнэ.
- 27. Орон сууцны ипотекийн зээлд хамрагдах нөхцөл, шаардлагыг багасгаж олон залуу гэр бүлийг орон сууцанд хамрагдах бодлого хэрэгжүүлнэ.
- 28. Иргэдийнхээ Газрын тухай хуульд заасны дагуу газар эзэмшиж ашиглах, түүн дээрээ хөнгөлөлттэй нөхцөлөөр хувийн орон сууц барих, шинэ суурьшлийн бүс байгуулах боломжийг бодлогоор дэмжинэ.

Нийгмийн бодлого

- 29. Дархан-уул аймгийн хэмжээнд ажилгүйдэл, ядуурлын судалгааг баг, сум, аймгийн түвшинд бодитой гаргаж, бууруулах зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлон холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах оновчтой бүтэц, удирдлагыг хэрэгжүүлэн ядуурлыг 20 хувиар бууруулна.
- 30. Дархан-Уул аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хувийн болон төрийн өмчит ЕБС-ийн нийт хүүхдүүдэд боловсролын зээлийн санд хамрагдах нөхцөл боломжийг бодлогоор дэмжинэ.
- 31. Дархан-Уул аймгийн хэмжээнд бага орлоготой айл өрхүүдэд зориулсан орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 32. Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар аймгийн түвшинд бодлого хэрэгжүүлнэ.
- 33. Ерөнхий боловсрол сургуулийн багш, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар аймгийн түвшинд бодлого хэрэгжүүлнэ.
- 34. Дархан хотод өвлийн спортыг хөгжүүлэх, өвлийн спортын ордон байгуулах санаачилгыг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.

Тусгай хэрэгцээт хүмүүс

- 35. Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бусдын адил бизнес эрхлэх, сурч, хөдөлмөрлөх, бие даан амьдрахад нь туслах, сэргээн засах, нийгмийн харилцаанд ороход туслан дэмжих зэргээр тэдний хэрэгцээнд нийцсэн олон талт мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.
- 36. Дархан-Уул аймагт сэргээн засах, хөгжлийн цогцолбор төв байгуулна.
- 37. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тогтмол орлого олох хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 38. Нийгмийн үйлчилгээний байгууламжуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц, орчин бий болгоно.
- 39. Үйлчилгээний газар, шинээр баригдаж байгаа барилга, байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог хөгжлийн бэрхшээлтэй хүн чөлөөтэй зорчих олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн өөрчилнө.

Эрүүл мэнд, биеийн тамир, спорт

40. Эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг шаардлага оношилгоо, эмчилгээний орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх замаар эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
41. Хүн амыг халдварт болон халдварт бус өвчнөөс урдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагааг сайжруулах “Эрүүл Дарханчууд” төсөл хэрэгжүүлнэ.
42. Эрүүл мэндийн үйлчилгээг блокчейн технологид суурилсан бүртгэл, мэдээллийн систем ашиглан хөгжүүлж, хялбаршуулах төслүүдийг дэмжинэ.
43. Дархан хотын хүнсний захуудад ариун цэвэр, аюулгүй байдлын стандартыг чанд мөрдүүлнэ.
44. Баг бүрт иргэд эрүүл зөв хооллолт, стрессээ удирдах, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, бие бялдраа хөгжүүлэх дасгал хөдөлгөөн, иог, бүжиг хийх зэрэг цогц үйлчилгээ авах боломж бүхий “Эрүүл зөв амьдрал” жижиг төвүүд ажиллуулах боломжийг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор дэмжин хөгжүүлнэ.
45. Олон улсын стандартад нийцсэн бүсийн гуравдугаар түвшний эмнэлгийг барьж байгуулах ажлыг эрчимжүүлж, хугацаанд нь ашиглалтад оруулна.
46. 15 жил үргэлжилсэн Дарханы спорт цогцолборыг бүрэн ашиглалтад оруулж, менежментийн чадварлаг багийг сонгон шалгаруулж үйл ажиллагааг нь удирдуулна. Бүс нутаг, олон улсын чанартай тэмцээн уралдааныг тогтмол зохион байгуулах, дарханчууд биеийн тамираар хичээллэх, эрүүл мэндээ чийрэгжүүлэх дасгал суургуулалт хийх дугуйлангуудийг ажиллуулах боломжийг бүрдүүлсэн цогц, тасралтгүй үйл ажиллагааг явуулна.
47. Дархан хотод орчин үеийн Усан спортын сургалтын төвийг байгуулж хүүхэд залуучуудын эрүүл мэнд, бие бялдарын хөгжлийг дэмжих, усан спортын мэргэжлийн баг, тамирчдыг үе шаттайгаар бэлтгэнэ.
48. Хүүхэд, залуучууд багийн спортоор хичээллэх боломж нөхцөл, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд стандартын шаардлага хангасан сагсан бөмбөг, гар бөмбөгийн талбайг сум, баг бүрт байгуулах ажлыг холбогдох төрийн бус байгууллага, холбоодуудтай хамтран хэрэгжүүлнэ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан

49. Төрийн өмчийн сургууль цэцэрлэгийн захирал, эрхлэгчдийг улс төрөөс 100% хараат бус болгож, мерит тогтолцоогоор сонгогдох зарчмыг хэрэгжүүлнэ.
50. Сургууль, цэцэрлэгийн эцэг, эхийн зөвлөлийн үйл ажиллагааг шинэ түвшинд гаргана.
51. ЕБС-ийн хичээлийн цагт баригдахгүйгээр хичээлийн агуулгыг бүрэн нөхөх боломжийг хангана.

52. Хэн ч дэлхийн боловсролоос хоцрох ёсгүй. Дотоод, гадаадын их дээд сургуульд элсэх, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломж, боловсролын зээлийн тэгш хүртээмжтэй олгох бололцоог хангах үүднээс зөвлөгөө үйлчилгээний нэгдсэн төвийг байгуулна.
53. Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрүүд, Их, дээд сургуулиудыг түшиглэн Технологийн банк болон үйлдвэр технологийн паркуудыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулахыг дэмжинэ.
54. Дархан-Уул аймгийн эрдэс баялгийн салбарын хүний нөөцийг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх түвшинд бэлтгэж, дадлагажуулж, салбарын ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг аймгийн Их, дээд болон мэргэжлийн боловсролын коллежуудтай хамтран хэрэгжүүлнэ.
55. Аймгийн мэргэжлийн боловсролын сургуулиудад хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцсэн нарийн мэргэжлийн шинэ ангиуд нээх тал дээр үйлдвэр, аж ахуйн нэгжүүд, төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран ажиллана.
56. Дархан-уул аймагт үйл ажиллагаа явуулдаг шинжлэх ухаан, боловсролын байгууллагуудын нэгдсэн сүлжээ үүсгэж, уялдаа холбоог хангана.
57. Их, дээд сургууль, политехникийн коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг Дархан-Уул аймаг төдийгүй бүс нутгийн хүний хөгжлийн төв болгон хөгжүүлнэ.
58. Их, дээд сургууль, политехникийн коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд төгсөгчдийнхөө мэргэжил дээшлүүлэх асуудлыг хариуцдаг тогтолцоог бий болгож, насан туршийн боловсролын үйлчилгээний чиглэлийг нэмэгдүүлэн, насанд хүрсэн суралцагчдын ажил эрхлэх ур чадвар, амьдрах чадварын сургалтын хүрээнд төдийгүй шинэ чадвар эзэмшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр бий болгож хэрэгжүүлэхэд олон талт оролцоог хангана.
59. Аймгийн соёл урлагийн байгууллагын болон чөлөөт уран бүтээлчдэд ур чадвараа хөгжүүлэх, уран бүтээлээ олны хүртээл болгоход нь дэмжлэг үзүүлнэ.
60. Дархан-Уул аймгийн театр, соёлын төвүүдийг газруудыг улирлын чанарт тохируулан алдагдалгүй ажиллах боломжийг бүрдүүлнэ.

Бизнес, хөдөлмөр эрхлэлт

61. Улс төрийн нам эвслээс хараат бус чөлөөт бизнесийн орчныг бодлогоор дэмжинэ.
62. Дархан хотыг Монголын хамгийн том ложистик-худалдаа, арилжааны зангилаа төв болгон хөгжүүлж, жижиг, дунд үйлдвэрлэлийн экспортыг дэмжин, ажлын байрыг нэмэгдүүлэхийг бодлогоор дэмжиж ажиллана.

- 63. Аймгийн бизнес хөгжүүлэх төв буюу инновацийн төвийг барьж, бизнес эрхлэгчдийг дэмжин, аймгийн эдийн засгийг сайжруулна.
- 64. Блокчэйн технологид суурилсан бизнесийн арилжаа, төлбөр тооцооны систем нэвтрүүлэх санал, санаачилгыг бүх талаар дэмжиж ажиллана.
- 65. 10,000 айлын орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх замаар барилгын салбарт ажиллагсдын бодит орлогыг нэмэгдүүлнэ.
- 66. Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт хэрэгжих бүтээн байгуулалтын томоохон төслүүдэд орон нутгийн иргэдийг түлхүү хамруулах талаар боломжит бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 67. Дархан-Уул аймагт он удаан жил хүлээгдэж байгаа бүтээн байгуулалтын төслүүдийг үргэлжлүүлэх, цаг хугацаанд ашилалтад нь хүлээлгэн өгөх тал дээр онцгойлон анхаарч ажиллана.
- 68. Техник, эдийн засгийн үндэслэл нь хийгдсэн, санхүүжилт нь боссон, богино хугацаанд үр ашиг авчрах төслүүдийг сонгож, хэрэгжилтийг эрчимжүүлнэ.
- 69. Дархан-Уул аймгийн зам, тээврийн салбарын болон тээврийн логистикийн бодлогыг "Darkhan Hub" төслийн хүрээнд боловсруулан хэрэгжүүлнэ.
- 70. Дархан-Уул аймгийн тээврийн салбарт дэвшилтэт техник технологи, инновац, дижитал шилжилтийг нэвтрүүлж, тээвэрлэлтийн аюулгүй, найдвартай байдлыг хангана.
- 71. Тээвэр логистикийн "Darkhan hub" төвийг барьж ашиглалтад оруулах, тээврийн шинэ төрлүүдийг хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ.
- 72. Амралт, зуслангийн зориулалттай авто замын сүлжээ, дэд бүтцийг хөгжүүлнэ.
- 73. Дархан-Уул аймагтаа өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлд гаргасан санал санаачилга, хөтөлбөр, арга хэмжээг идэвхтэй дэмжинэ.
- 74. Дархан-Уул аймгийн хэмжээнд усан сан (Хөв цөөрөм) байгуулж усны нөөцийг нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлнэ.
- 75. Дархан хотын ДДЦС-ийн хүчин чадлыг 50-100 МВт хүртэл нэмэгдүүлэх, шинээр 100 мВт хүчин чадалтай дулаан, цахилгааны нэмэлт эх үүсвэрийг байгуулах замаар эрчим хүчний хараат байдлаас гаргаж, үйлдвэрийн болон ахуйн дулааны хангамжийг хүчин чадлын хомсдлоос гаргана.
- 76. Айл өрх, аж ахуйн нэгжүүд сэргээгдэх эрчим хүчний бие даасан эх үүсвэрээр өөрийн эрчим хүчний хэрэглээг хангах хууль эрх зүйн зохицуулалтыг дэмжиж, илүүдэл эрчим хүчээ эрчим хүчний системд нийлүүлэх хууль эрх зүйн орчныг бий болгох талаар бодлогоор дэмжинэ.


Аж үйлдвэржилт, ажлын байр

- 77. Дархан-Уул аймагт эрдэс баялгийн болон малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөдөө аж ахуй, хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэн ажлын байр бий болгоно.

- 78. Малаас гарч буй түүхий эд болох арьс шир, ноос ноолуурыг боловсруулах үйлдвэрлэлийн "Дархан арьс ширний цогцолбор"-ын бүтээн байгуулалтыг бүх талаар дэмжин үргэлжлүүлнэ.
- 79. Хөнгөн үйлдвэрлэлийн төв болгон хөгжүүлэх бодлогыг улс, бүсийн хэмжээнд боловсруулж ажиллана.
- 80. Улс бүсийн хэмжээнд Дархан -Уул аймагтаа олимпизмын бааз нэгдсэн төвийг бий болгох зорилт дэвшүүлж, олимпийн төрлийн бүх спорт хөгжих боломж бололцоог бүрдүүлэх нэгдсэн төвийг байгуулна.
- 81. Дархан-Уул аймагт хойд бүсийн барилгын материалын худалдааны төв байгуулах бизнесийн орчинг дэмжин ажиллана.

Мал аж ахуй

- 82. Аймгийн малчин өрхүүдийг хүчин чадал өндөртэй технологи, техник, цахилгаан хэрэгсэл ашиглах боломжоор хангаж, бодлогоор дэмжинэ.
- 83. Аймгийн малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийг сэргээнэ.
- 84. Аймгийн малчин өрхүүдийг дэмжин малын үүлдэр угсааг сайжруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх "эрчимжсэн мал аж ахуй" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 85. Хойд бүсийн нэгдсэн Фермэрийн аж ахуйг байгуулах хөгжих бололцоог хангаж хүнсний аюулгүй байдлыг ханган хэрэгжүүлнэ.
- 86. Уламжлалт мал аж ахуйгаа дэмжих замаар бэлчээрийн даацаа зохистой төлөвлөж орон нутагт малчидын эрх ашгийг хамгаалах, хөгжүүлэх бодлогыг малчидтайгаа хамтран хэрэгжүүлнэ.
- 87. Мал аж ахуйн салбар малаас гарах түүхий эдийг боловсруулах технологийг шинэ түвшинд гаргах замаар үнэлэмжийг нэмэгдүүлэх бодлогыг хамтран хэрэгжүүлнэ.
- 88. Дархан хотын хүнсний нийтийн хэрэглээний малыг зөвхөн үйлдвэрийн аргаар нядалж боловсруулах чиглэлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.



Газар тариалан

- 89. Хонгор, Шарын гол, Орхон сумдад хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэн иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлнэ.
- 90. Газар тариалангийн бүс нутагт услалтын системийн менежментийг боловсронгуй болгож, тариалан эрхлэгч, хүнсний ногоо тариалагчдыг бодлогоор дэмжинэ.
- 91. Газар тариалангийн үйлдвэрлэлийн мэргэжлийн ажиллах хүчний хангамж, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 92. Орхон сумын жимс, жимсгэнэ, нарийн ногоо тариалалтыг бүхэлд нь дэмжиж тариалах газар, хүлэмжийн газар олгох, ашиглахад уян хатан бодлого

баримтална. Энэ салбарт гадаадын мэргэжилтнүүд урьж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана.

93. Төмс, хүнсний ногооны хангамж, хүртээмжийг тогтворжуулах зорилгоор хувийн аж ахуйн нэгжүүд хадгалах зоорь барьж байгуулахыг бодлогоор дэмжинэ.
94. Дархан-уул аймгийн хэмжээнд хүн амын хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг аюулгүй, чанартай хүнсээр хүртээмжтэй, тогтвортой хангах нөхцлийг бүрдүүлнэ.

Төрийн үйлчилгээ

95. Өндөр хурдны интернэтийн сүлжээг хүртээмжтэй болгож "Цахим хот" хөтөлбөр хэрэгжүүлж иргэн, аж ахуйн нэгж бүрт цаг алдалгүй шуурхай үйлчилгээ авах, бизнес эрхлэх боломжийг бүрдүүлсэн хүнд сурталгүй, дарамтгүй төрийн үйлчилгээг бий болгоно.
96. Мэргэшсэн нийтийн алба, иргэний оролцоот үнэлгээ, хариуцлагын тогтолцоо бүхий нийтийн үйлчилгээг бэхжүүлж, салбарын мэргэшсэн ажилтнуудыг улс төрөөс ангид, тогтвортой ажиллуулах бодлого баримтална.
97. Аймгийн нийт төрийн албан хаагчдыг эрхэлдэг ажлынхаа чиглэлээр мэргэших, сурч боловсрох, тасралтгүй хөгжих боломжоор хангах сургалт-хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.
98. Дархан-Уул аймагт төрийн албан хаагчдыг нам дагасан томилгооноос салгана.
99. Дархан-Уул аймагт салбарын мэргэшсэн албан хаагчдыг улс төрөөс ангид, мөрит зарчимд суурилсан тогтвортой байх зарчмыг хэвшүүлнэ.
100. Төрийн үйлчилгээнд хувийн хэвшил, иргэний оролцоот үнэлгээ, хариуцлагын тогтолцоог нэвтрүүлнэ.
101. Дархан-Уул аймгийн иргэд, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлнэ.
102. Цахим өргөдөл, гомдлын төвийг байгуулан ажиллуулна.
103. Дархан-Уул аймагт өндөр хурдны интернэтийн сүлжээг түгээж, иргэд төрийн байгууллагад биеэр очилгүй төрийн үйлчилгээг цаг алдалгүй шуурхай авах боломж бүрдүүлнэ.
104. Төрийн үйлчилгээг блокчейн технологид суурилсан бүртгэлийн систем ашиглан хөгжүүлж хялбаршуулах төслүүдийг дэмжинэ.

Байгаль орчин, экологи

105. Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа уурхайнуудын хяналт, нөхөн сэргээлт, хаалтын стандартыг мөрдүүлж, дүйцүүлсэн нөхөн сэргээлтийг ногоон хөгжлийн бодлоготой уялдуулна.
106. Дархан хотын ундны цэвэр усыг хэмнэх, эх үүсвэрийг хамгаалах төсөл хэрэгжүүлэх замаар хаягдал саарал усыг цуглуулах, хуримтлуулах, цэвэрлэх, дахин ашиглах үйлдвэрийг цэвэрлэх байгууламжтай уялдуулан байгуулна.

Хаягдал ус болон борооны усыг үйлдвэрлэл, бүтээн байгуулалтын ажилд дахин ашиглана.

107. Дархан-Уул аймагт мөрдөгдөх хог хаягдлын менежментийг зохицуулах журам батлан мөрдүүлнэ.
108. Сууц өмчлөгчдийн холбоодод учирдаг хог хаягдлын ачилт, тээвэрлэлтийн зардалтай холбоотой асуудлыг оновчтой шийдвэрлэж, хүндрэл чирэгдэлгүй байдлаар зохицуулна.
109. Дархан хот болон сумдын орчинд үүссэн хог хаягдлыг бууруулах, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хаягдлыг төрлөөр нь ангилан, анхан шатны боловсруулалтын бага оврын үйлдвэрүүдийг кластераар хөгжүүлэх замаар дахивар нөөцийн парк байгуулна.
110. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажиллагааг хэвшүүлж, дахин боловсруулах, эрчим хүч гаргах байгаль орчинд хор, нөлөөгүй үйлдвэр байгуулах санаачлагыг дэмжиж ажиллана.
111. Дэлхийн Карбон (нүүрстөрөгчийн эслэг)-ы зах зээлээс хөрөнгө оруулагч татах аж ахуйн нэгжүүдийн санаачилгыг бодлогоор дэмжинэ.

Хотын хөгжил

112. Дархан-Уул аймгийн Дархан сумыг улсын түвшний хотын статустай болгож, бие даасан хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
113. Дархан хотын авто замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, зогсоолын хүрэлцээг шийднэ.
114. Дархан хотын зарим гудамжийг явган хүнд зориулсан, худалдаа үйлчилгээний "авто машингүй гудамж" болгоно.
115. Дархан хотдоо үйл ажиллагаа эрхэлж буй орчноо ногооруулсан иргэд, аж ахуйн нэгжийг дэмжих бодлого боловсруулна.
116. Дархан-Уул аймагтаа спортын, эрүүл мэндийн, явган алхалт, эко-туризмын нүүдэлчний өв соёлоо сурталчлах зэрэг аялал жуулчлалын төрөл хэлбэрүүдийг дэмжинэ.
117. Дархан-Уул аймгийн иргэд амьдралд эергээр нөлөөлөх, жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх аялал жуулчлалын дэд бүтцэд хувийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
118. Дархан хотын аялал жуулчлал, үйлчилгээний салбарын ажиллах хүчний ур чадварыг хөгжүүлнэ.
119. Дархан хот Улсын болон Олон улсын чанартай тэмцээн, уралдаан, соёл урлаг, үзэсгэлэн худалдааны арга хэмжээг зохион байгуулах эрхийг авах, бэлтгэх ажлыг хангах талаар бодлогоор онцгой анхаарч, төр ба хувийн хэвшлийн хамтын хүчээр дэмжиж ажиллана.

- 120. Дархан хотын эрсдэл бүхий газруудыг камержуулж, цагдаагийн байгууллагатай шууд, хялбар байдлаар холбогдох тоноглолыг хийсэн “Ногоон бүс” буюу аюулгүй бүсийг бий болгож дэмжинэ.
- 121. Дархан хотын нийтийн эзэмшлийн зам, талбай дахь камержуулалтын ажлыг хийх журам, холбогдох эрх зүйн баримт бичгийг гаргаж, хувь хүний нууцыг хадгалахтай холбоотой асуудлыг анхаарна. “Манаачийг манах” буюу мэдээллийн дата-тай ажиллаж буй холбогдох эрх бүхий албан тушаалтныг хянах технологийн болон үйл ажиллагааны боломжуудыг бүрдүүлнэ.
- 122. “Шүршүүр-жорлон” хөтөлбөрийг Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж байгаа шатахуун түгээх станц болон өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний дэлгүүрүүдэд санал болгож, хамтран хэрэгжүүлнэ.
- 123. Дархан хотын гэр хорооллын инженерийн дэд бүтэц /цэвэр ус, бохир ус ариутгах татуурга, интернэт шилэн кабель/-д холбож, халаалтыг төвлөрсөн болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлж, амьдран суух байшингаа барихад нь урт хугацаатай, хүү багатай, орон сууцны ипотекийн зээлд хамрагдахад дэмжлэг үзүүлж ажиллана.
- 124. Дархан хотын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг эдийн засаг, нийгмийн үр ашгаар эрэмбэлэн, санхүүжүүлэх, хөрөнгө оруулалтын сан байгуулж, нэгдсэн менежментийн тогтолцоог бүрдүүлнэ.
- 125. Гэр хорооллын дундын болон захын бүсийг тэргүүн ээлжинд инженерийн дэд бүтэцтэй болгоход улс, орон нутгийн төсөв болон бусад хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зориулах, иргэдийн хүсэл, санаачилгад үндэслэн дэд бүтэц бүхий газрыг төр, эсхүл хувийн хэвшлийн орон сууцаар шууд солих замаар дараагийн орон сууц баригдах талбайг бий болгоно.
- 126. Гэр хорооллын өрхийн газрыг өөрсдийн нь идэвх, санаачилга, оролцоонд тулгуурлан дахин зохион байгуулах, нийгмийн болон инженерийн дэд бүтэц, ногоон байгууламж, тоглоомын талбай бий болгох үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, улсын төсөв болон бусад хуулиар хориглоогүй эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжийг бий болгоно.
- 127. Хотын ногоон байгууламжийг хамгаалах, нэмэгдүүлэх, хотын соёлыг бүрдүүлэхэд иргэдийн оролцоотой хяналтын тогтолцоог бэхжүүлнэ.
- 128. Гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж бүрэн камержуулан, ард иргэдийн аюулгүй байдлыг хангаж, гудамж, талбайн нэр, байшин барилгын хаягийн нэгдсэн стандарт хангуулж, хотын соёлыг нэмэгдүүлнэ.
- 129. Дархан хотын зуслангийн бүсийг шинээр төлөвлөн бие даасан дэд бүтцэд холбоно.
- 130. Дархан хотын орчны ногоон байгууламжид харшил үүсгэгч ургамалаас цэвэрлэх, устгах талаар мэргэжлийн лабораторитой хамтран шийдэл гаргаж

шарилж хогийн ургамлын хөнөөлийг тодорхойлох, тэдгээртэй тэмцэх оновчтой аргыг нэвтрүүлнэ.

- 131. Дархан хот болон аймгийн сумдын нутаг дэвсгэрт золбин нохой, муур, өвчилсөн тэжээвэр малыг устгах оновчтой шийдэл бүхий арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, иргэдийн аюулгүй байдлыг хамгаалж, амьтнаас үүсэлтэй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ.
- 132. Дархан хотын явган хүний зам, талбайг оновчтой төлөвлөн байгуулна.
- 133. Сууц өмчлөгчдийн холбоо, хөршийн холбооны ажилтнуудыг мэргэшүүлэх, туршлагажуулах "Шилэн СӨХ" төслийг санаачлан хэрэгжүүлнэ.
- 134. Хотын орчинд үүссэн шороон шуургаас үүдэлтэй тоосжилтийг бууруулах арга хэмжээг моджуулах хөтөлбөр, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, усны нөөцийн сан байгуулах үйл ажиллагаатай уялдуулна.

Сумдын хөгжил

- 135. Шарын гол сумын бичил уурхайн шаардлага хангасан зарим нөхөрлөл, хоршоог уул уурхайн олборлолтын аж ахуйн нэгж хэлбэрээр албажуулж, үйл ажиллагааг нь дэмжинэ.
- 136. Шарын гол сумын иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлсан орон сууцны төслийг дэмжинэ.
- 137. Хонгор сум, Салхит багт иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлсан орон сууцны төслийг дэмжинэ.
- 138. Шарын гол, Хонгор сумын дулааны эрчим хүчний эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийг дэмжинэ.
- 139. Хонгор, Шарын гол, Орхон сумдын хөдөө аж ахуйн боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, санхүүжилтийн найдвартай тогтолцоо бий болгох, олон улсын стандарт нутагшуулах, худалдан борлуулах, экспортлох цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Бүтээн байгуулалт, дэд бүтэц

- 140. Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган орон сууцаа чөлөөлсөн иргэдийг орон байраар хангах замаар шинээр нийтийн зориулалттай орон сууцны барилга барих, дахин төлөвлөх төслийг хэрэгжүүлнэ.
- 141. Угсармал болон хуучин орон сууцуудын дээврийг засварлах, дулаан алдагдлыг багасгах, дулаалга, их засвар хийж, эрчим хүч хэмнэх төслийг хувийн хэвшил, сууц өмчлөгчидтэй санаачлан хэрэгжүүлнэ.
- 142. Орон сууцны сантехникийн шугамуудыг засварлан шинэчилж эрчим хүчний зарцуулалт, нүүрстөрөгчийн ялгаралыг багасгаж, иргэдийн амьдрах орчныг сайжруулан, орон сууцны үнэлгээг нэмэгдүүлнэ.

- 143. Нийтийн үйлчилгээний газруудын гадна тайлбайн бороо, үерийн ус зайлуулах тогтолцоог мэргэжлийн байгууллагууд болон тухайн аж ахуйн нэгжтэй хамтран шийдвэрлэнэ.
- 144. Орон сууцны хорооллын бороо, үерийн ус зайлуулах тогтолцоог холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран оновчтой төлөвлөн шийдвэрлэнэ.
- 145. Гэр хорооллын бороо, үерийн ус зайлуулах тогтолцоог холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран оновчтой төлөвлөн шийдвэрлэнэ.

